



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

МУБИС-ийн сурах бичиг, гарын авлагад
тавих шаардлагын тухай

“МУБИС-ийн дүрэм”-ийн 4.6.2, 4.6.13 дахь заалт, “МУБИС-ийн багшийн ажиллах журам”-ийн 3.3, 4.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “МУБИС-ийн сурах бичиг, гарын авлагад тавих шаардлага”-ыг шинэчлэн хавсралтаар баталсугай.


2. Энэхүү шаардлагыг МУБИС-ийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд суралцагчдад зориулсан сурах бичиг, гарын авлага боловсруулах, тэдгээрт мэргэжлийн дүгнэлт гаргах, үнэлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагаанд мөрдүүлэн ажиллахыг Сургалт, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор (Д.Соронзон)-т үүрэг болгосугай.

РЕКТОР



Ж.БАТБААТАР

1426010446



МУБИС-ийн СУРАХ БИЧИГ, ГАРЫН АВЛАГАД ТАВИХ ШААРДЛАГА

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. МУБИС-ийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын үндсэн болон нэмэлт хөтөлбөрийн хичээлүүдийг судалж буй суралцагчдад зориулан туурвисан сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг дээшлүүлэх, улмаар олон улсын жишигт нийцсэн сурах бичиг, гарын авлагын сан бүрдүүлэхэд энэхүү шаардлагын зорилго оршино.

1.2. Энэхүү шаардлагыг сурах бичиг, гарын авлага бичих, үнэлэх, сонгон шалгаруулах зэрэгт жишиг болгон мөрдөнө.

1.3. Сурах бичиг, гарын авлага нь хэвлэмэл болон цахим хэлбэртэй байж болох ба дараах байдлаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:

А. Сурах бичиг – Хичээлийн стандартад нийцсэн, шинжлэх ухааны онол, хэрэглээний нэгдлийг хангасан, суралцагчдад бие даан системтэй мэдлэг, чадвар эзэмшихэд чиглэсэн, арга зүйн боловсруулалт бүхий сургалтын хэрэглэгдэхүүн.

Б. Гарын авлага – Хичээлийн тодорхой зорилго, зорилт бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд суралцагчийг чиглүүлэх, дэмжих зорилгоор боловсруулсан, үндсэн ойлголт, заавар, зөвлөмж, жишээ, шаардлагыг системтэйгээр нэгтгэн тайлбарласан сургалтын хэрэглэгдэхүүн.

Хоёр. НИЙТЛЭГ ШААРДЛАГА

2.1. Сурах бичиг, гарын авлага нь мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөр болон хичээлийн стандарттай нийцсэн байна. Гарын авлага нь МУБИС-ийн нэмэлт сургалт, дугуйлан зэрэгт зориулсан, гадаад хэлээр болон баррель үсгээр бичигдсэн байж болно.

2.2. Сурах бичиг, гарын авлага нь шинээр зохиосон, дахин сайжруулж боловсруулсан, орчуулсан байж болно. Онолын болон логик зөрчилгүй, агуулга, арга зүйн хувьд уламжлал шинэчлэлийг зохистой хослуулсан байна.

2.3. Өмнө нь хэвлэгдсэн сурах бичиг, гарын авлагын агуулгад 30 болон түүнээс доошгүй хувийн өөрчлөлт хийж шинэчлэн боловсруулсан бол дахин сайжруулж боловсруулсан гэж үзнэ.

2.4. Орчуулгын сурах бичиг нь МУБИС-ийн хэрэгжүүлж буй мэргэжлийн хөтөлбөрийн нэг эсвэл хэд хэдэн хичээлд хэрэглэгдэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын их сургуулийн сурах бичиг байна. Орчуулгын сурах бичгийг МУБИС-ийн сурах бичигтэй адилтган үзэж, тухайн хичээлийн сурах бичиг болгон ашиглаж болно.

2.5. Орчуулгын сурах бичиг нь анхдагч эх бүтээлийн бүтэц, хэлбэршлийг баримталсан, зохиогчийн эрх эзэмшигчээс орчуулах, хэвлүүлэх зөвшөөрөл авсан байна.

2.6. Сурах бичиг, гарын авлага нь зохиогчийн эрхийн зөрчилгүй байна.

2.7. Сурах бичиг, гарын авлага нь агуулгын болон техникийн редактораар хянан тохиолдуулсан байна.

2.8. Хэл найруулга зөв оновчтой, товч тодорхой, энгийн ойлгомжтой, эмх цэгцтэй, зөв бичих дүрмийн алдаагүй байна.

2.9. Хэсэг, бүлэг, сэдвийн гарчиг, дэд гарчгууд нь агуулгын үзэл санаа, бүтэц, үндсэн нэр томъёог оновчтой илэрхийлсэн байна.

2.10. Ном зүй, эшлэл, зүүлтийг олон улсын APA (American Psychology Association), IEEE (Institute for Electrical and Electronics Engineers), Chicago, MLA (Modern Language Association) гэх мэт тухайн шинжлэх ухааны салбарт нийтлэг хэрэглэгддэг стандартаар хийсэн байна.

2.11. Агуулга, арга зүй, үнэлгээний хэсэг тус бүрийн дотоод бүтэц, логик ялгааг таних, мэдээллийг хурдан хүлээн авахуйц өнгийн зохицол, хэмжээ, таних тэмдэг, түлхүүр үгийг хэрэглэсэн байна.

2.12. Үг, үсэг нь уншигдахуйц сайтай, мөр хоорондын зай бүх хуудсанд ижил, бүлгийн нэр, дэд болон туслах гарчиг, үндсэн бичвэр, тайлбар, даалгавар зэрэг элементийг төрөл тус бүрээр ижил хэмжээтэй, нэг загвараар хийсэн байна.

2.13. Зураг, бүдүүвч, график, хүснэгт зэргийг ашигласан байж болох ба эдгээр нь дугаар нэртэй, агуулгыг тодорхой илэрхийлсэн, гоо зүйн шаардлага хангасан байна.

2.14. Шаардлагатай тохиолдолд хэрэглэсэн тэмдэглэгээ, код, товчлолын тайлбар, нэр томъёоны тайлбар болон товчилсон үгийн жагсаалтыг оруулсан байна.

2.15. Сурах бичиг, гарын авлага нь судлагдахууны агуулгын цар хүрээ, судлах цагийн хэмжээ, суралцахуйн үр дүнд нийцсэн бүтэц, зохих хэмжээтэй байна. Сурах бичиг нь хамгийн багадаа 16 хэвлэлийн хуудас, гарын авлага нь хамгийн багадаа 8 хэвлэлийн хуудас байна.

2.16. МУБИС-ийн хэрэгжүүлж буй мэргэжлийн хөтөлбөрийн ерөнхий суурь, багш мэргэжлийн болон мэргэжлийн, мэргэшүүлэх хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээнд тохирч байгаа бол бусад их сургууль, академик сургалт судалгааны байгууллага, эрдэмтдийн гаргасан сурах бичиг, гарын авлагыг мэргэжлийн тэнхимийн хамт олны шийдвэрээр тухайн хичээлийн сурах бичиг, гарын авлагаар ашиглаж болно.

Гурав. ТУСГАЙ ШААРДЛАГА

А. СУРАХ БИЧИГ

3.1. Сурах бичиг нь доторх нүүр хуудас, номын товч тодорхойлолт, гарчиг, өмнөх үг, удиртгал, үндсэн хэсэг, ном зүй, хавсралт зэргийг агуулсан байх ба эдгээрийг дараах байдлаар тодорхойлж ойлгоно.

Үүнд:

- Дотор нүүр хуудас - Номын тухай анхдагч мэдээлэл бүхий эхний нүүр хуудас. Дотор нүүр хуудсанд холбогдох сургууль, тэнхимийн нэр, зохиогчдын нэрс, номын нэр, товч тодорхойлолт, хэвлэлийн хуудас, хэвлэгдсэн он, хэвлэлийн газар, ISBN дугаар, зохиогчийн эрхийн талаарх тэмдэглэл зэргийг багтаасан байна.

- Номын товч тодорхойлолт - Номын зориулалт, үндсэн агуулга, төрөл, хэлбэр зэрэг онцлог шинжийн талаарх мэдээлэл агуулсан товч тодорхойлолт.

- Гарчиг - Номын агуулгын бүтэц, сэдвийн талаар ерөнхий төсөөлөл өгч буй лавлагаа - мэдээллийн цогц.

- Өмнөх үг - Тухайн хэрэглэгдэхүүний зориулалт, сургалтын ач холбогдол, онцлог шинжийн талаарх тодорхойлолт.

- Удиртгал - Судлагдахууны чухал тал, онол, хэрэглээний ач холбогдол, судлагдахууны түүхэн тойм, хөгжлийн хандлага, суурь ойлголтын тогтолцоо, сурах бичгийн бүлэг бүрийн агуулгын тодорхойлолт, зарчим, арга зүй зэргийг тоймлон дурдсан зохиогчийн өгүүлэмж.

- Үндсэн хэсэг - Судлагдахууны шинжлэх ухааны онол, үзэл баримтлал, үндсэн ойлголт, арга зүй, хэрэглээг системтэйгээр тайлбарласан гол агуулгын хэсэг. Энэ хэсэг нь бүлэг, дэд бүлэг, сэдэв, агуулгын дараалсан бүтэцтэй байх бөгөөд суралцагчид тухайн судлагдахууны мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшихэд чиглэсэн тайлбар, жишээ, зураг, хүснэгт, кейс, дасгал, даалгавар, эргэцүүлэл, үнэлгээг багтаасан байна.

- Бүлэг - Тухайн бүлгийн агуулгын товчоон, өмнөх бүлгүүдтэй уялдуулсан үндсэн ойлголт, бүлгийн гол агуулга/сэдэв, товч дүгнэлт, мэдлэгээ бататгах практик дасгал, даалгавар, асуулт, хариулт зэргээс бүрдсэн үндсэн хэсэг. Бүлгийн эхэнд тухайн бүлгийн товч агуулга, эзэмших мэдлэг, чадвар, гол ухагдахуун, түлхүүр үг зэргийг тодорхойлсон онцлог бүтэцтэй байж болно.

- Сэдэв/Агуулга - Агуулга нь шинжлэх ухааны онол арга зүйн зохих түвшинд бичигдсэн, хоорондоо логик уялдаа холбоотой, товч тодорхой, суралцахуйд суурилсан, арга зүйн боловсруулалт хийгдсэн, сэдэв бүрд тулгамдаж буй болон шийдвэрлэх асуудал, практик хэрэглээ, дасгал, даалгавар, эргэцүүлэл, үнэлгээ зэргийг тусгасан хэсэг.

- Ном зүй - Судлагдахууны агуулгыг цаашид гүнзгийрүүлэн эзэмшихэд зориулан зохиогчоос зөвлөж буй ном, бүтээлийн жагсаалт.

- Хавсралт - Үндсэн агуулгыг дэлгэрүүлж, гүнзгийрүүлэх зориулалт бүхий нэмэлт материал.

3.2. Сурах бичгийн агуулгад тавих шаардлага

3.2.1. Агуулгын багтаамж, бүтэц нь танин мэдэхүйн хөгжлийн үе шат, боловсролын түвшний залгамж холбоог хангасан, хичээлийн агуулгыг бүрэн хамарсан, бусад судлагдахуунтай холбогдсон, нээлттэй байна.

3.2.2. Судлагдахууны шинжлэх ухааны онолыг технологийн ололт амжилт, мэдлэгийг бусад салбарын онол, хэрэглээтэй холбосон байна.

3.2.3. Суралцагчийн сонирхол, хэрэгцээнд нийцсэн, даяаршлын ба үндэсний, салбар болон мэргэжлийн тулгамдсан асуудлыг хөндөж, хэрэглээний тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байна.

3.2.4. Шинэ мэдлэг эзэмшихэд туслах онолын материалаас гадна, шаардлагатай тохиолдолд нэмэлт болон тайлбар материалын эх сурвалжийг сурах бичигт зааж өгсөн байна.

3.2.5. Үг, утга санааг олон давтах, давхардуулахаас зайлсхийж, үнэн зөв, бодитой, үндэслэлтэй тодорхойлолт, үзэл баримтлал, үг хэллэг, нэр томъёог ашигласан байна.

3.3. Арга зүйд тавих шаардлага

3.3.1. Танин мэдэхүйн онол, суралцахуйн зүй тогтол, зарчимд нийцсэн, сурахуйн үйлийн баримжаа тодорхой, гүйцэд байна.

3.3.2. Шинжлэх ухааны нарийн төвөгтэй асуудлыг тухайн мэргэжлийн болон салбарын онцлогт тохируулан илэрхийлсэн, энгийн, ойлгомжтой, практик жишээн дээр загварчлан үзүүлсэн байна.

3.3.3. Мэдлэг, чадвараа практикт хэрэглэх, эргэцүүлэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, шинэ нөхцөлд шилжүүлэн турших, үнэлэх зэргээр суралцагчдад бие даан хөгжих боломж, нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3.3.4. Мэдээлэл хайх, ашиглах, боловсруулах, мэдлэг эзэмших/эзэмшүүлэхэд чиглэсэн мэдээллийг илэрхийлэх олон арга, хэлбэрийг хослуулан тохиромжтой байдлаар ашигласан байна.

Б. ГАРЫН АВЛАГА

3.4. Гарын авлага нь дараах хэлбэртэй байж болно. Үүнд:

Сургалтын гарын авлага - Сургалтын зорилго, агуулга, арга зүй, суралцах үйл ажиллагаа, үнэлгээний шалгуурыг нэгтгэн багтаасан суралцагчийн танин мэдэхүй болон бие даан суралцах үйл явцыг дэмжихэд чиглэсэн сургалтын дидактик хэрэглэгдэхүүн. Сургалтын гарын авлага нь суралцагчийн идэвхтэй суралцах үйл ажиллагааг дэмжих үүднээс Блумын таксономын хэрэглэх, турших, бүтээх танин мэдэхүйн чадваруудыг гол шалгуур болгодог.

Арга зүйн гарын авлага - Сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, суралцахуйн үйл, багшлахуйн арга зүй, үнэлгээ, хичээлийн төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга, алхам, технологийг тайлбарласан, практик хэрэглээнд суралцахад зориулсан хэрэглэгдэхүүн.

Бие даан гүйцэтгэх болон төсөлт ажлын гарын авлага - Суралцагчийн бие даан суралцах, судлах, асуудал шийдвэрлэх, төсөл боловсруулах, гүйцэтгэх үйлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай зорилго, бүтэц, шалгуур, арга зүй, үнэлгээний аргыг нэгтгэн тодорхойлсон хэрэглэгдэхүүн.

Лаборатори, практик, дадлагын гарын авлага - Практик ажил, лабораторийн туршилт, дадлага, бодит үйл ажиллагаа зохион байгуулахад шаардлагатай заавар, аргачлал, аюулгүй ажиллагааны дүрэм, гүйцэтгэлийн дараалал, арга зүйг тусгасан сургалтын хэрэглэгдэхүүн. Лабораторийн болон практик ажлын үйлдлийн дараалал-алгоритм, кейс, симуляци, дадлагын ажлын тайлбар, тайлан боловсруулах заавар зэрэг хэлбэртэй байж болно.

3.5. Гарын авлагын агуулгад тавих шаардлага

3.5.1. Гарын авлагын агуулга нь хичээлийн суралцахуйн үр дүнг хэрэгжүүлэхэд баримжаалсан мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн байна.

3.5.2. Гарын авлагын агуулга нь суралцагч бие даан ажиллах, турших, харьцуулах, шинжлэн судлах, үнэлэх зэрэг танин мэдэхүйн үйлд тулгуурласан байна.

3.5.3. Гарын авлагад суралцагч даалгаврын гүйцэтгэлдээ өөрийн үнэлгээ хийх болон багшийн үнэлгээ өгөх арга, хэлбэр, шалгуур үзүүлэлт зэргийг багтаасан байна.

3.5.4. Практик давамгай аргачлал, заавар, жишээ, зөвлөмжид суурилсан асуудал, шийдлийн арга, алхамчилсан заавар, туршлага, кейсэд суурилсан агуулгын нэгжийг бүрдүүлсэн байна.

3.6. Гарын авлагын арга зүйд тавих шаардлага

3.6.1. Судлагдахууны агуулгыг энгийн, хялбар, ойлгомжтой болгож, хэрэглээтэй холбосон жишээ баримтаар баяжуулан тайлбарласан, тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байна.

3.6.2. Суралцагчдад суралцахуйн үйлээ бүтээлчээр зохион байгуулж, нээлт, бүтээл хийх арга замыг зөвлөсөн, бие даан дэлгэрүүлэн уншиж судлах нэмэлт мэдээллийн эх үүсвэрийг оновчтой сонгож тусгасан, үйл ажиллагааг хөтлөх, арга туршлага эзэмшихэд хөтлөн чиглүүлсэн байна.

3.6.3. Суралцагчийн суралцахуйн үйлд тохирсон, сурах арга барил эзэмших, түүнийг бататгах, эргэцүүлэл хийх боломж олгохуйцаар боловсруулсан байна.

Дөрөв. СУРАХ БИЧИГ, ГАРЫН АВЛАГАД ТООЦОХ

4.1. Сурах бичиг, гарын авлагыг боловсруулж эхлэхээс өмнө түүний бүтцийг мэргэжлийн тэнхимээр хэлэлцүүлэн батлуулсан байна.

4.2. МУБИС-ийн сурах бичиг нь МУБИС-ийн нэр, лого таних тэмдэг¹, олон улсын болон Монгол улсын индекс (ISBN), DDC код авсан байна.

4.3. Боловсруулсан сурах бичиг, гарын авлагыг мэргэжлийн хоёроос доошгүй шинжээчээр уншуулж дүгнэлт гаргуулсан байна. Шинжээч нь тухайн шинжлэх ухаан, арга зүйн чиглэлээр мэргэшсэн, сурах бичиг, гарын авлага боловсруулж байсан туршлагатай, нэр хүндтэй эрдмийн зэрэг цолтой багш, судлаач байна.

4.4. Шинжээч нь сурах бичиг, гарын авлагад мэргэжлийн дүгнэлт гаргахдаа энэхүү шаардлагад тодорхойлсон шалгуур үзүүлэлтийг баримтална.

4.5. Гарын авлагыг шинжээчийн дүгнэлтэд үндэслэн мэргэжлийн тэнхимийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэн нийтлэг болон тусгай шаардлага хангасан талаар

¹ МУБИС-ийн албан ёсны нэр, лого

шийдвэр гарсан бол МУБИС-ийн нэр, лого ашиглах асуудлыг “МУБИС-ийн оюуны өмчийг бүртгэх, хадгалах, ашиглах, эзэмших журам”-аар зохицуулна.

4.6. Сурах бичгийг шинжээчийн дүгнэлтэд үндэслэн мэргэжлийн тэнхимийн өргөтгөсөн хурал, бүрэлдэхүүний сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн нийтлэг болон тусгай шаардлага хангасан тухай шийдвэр гарсан тохиолдолд МУБИС-ийн нэр, лого ашиглах асуудлыг “МУБИС-ийн оюуны өмчийг бүртгэх, хадгалах, ашиглах, эзэмших журам”-аар зохицуулна.

4.7. МУБИС-ийн сурах бичиг, гарын авлага нь цахим болон хосолсон сургалтад ашиглахад зориулсан цахим хэлбэртэй байж болно.

4.8. МУБИС-ийн цахим сурах бичиг, гарын авлагыг боловсруулахад уг шаардлагын 1, 2 болон 3 дугаар зүйлүүдийг, хэлэлцүүлэн баталгаажуулахад уг шаардлагын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 4.3, 4.4, 4.5, 4.6 заалтуудыг баримтална.

4.9. Цахим сурах бичиг, гарын авлагыг боловсруулахад уг журмаас гадна “МУБИС-ийн цахим сургалтын журам”, “МУБИС-ийн онлайн хичээлд тавигдах шаардлага”-ыг баримтална.


4.10. МУБИС-ийн сурах бичиг, гарын авлагад зохиогчийн эрхийн гэрчилгээ авах, бүтээлээ хамгаалуулах, эдийн засгийн эргэлтэд оруулахыг “МУБИС-ийн оюуны өмчийг бүртгэх, хадгалах, ашиглах, эзэмших журам”-аар зохицуулна.

4.11. МУБИС-ийн сурах бичиг, гарын авлагыг бүртгэх, мэдээллийн жагсаалтыг хөтлөх, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг Эрдэм шинжилгээ, инновацийн алба хариуцна.

---oOo---

Сурах бичиг, гарын авлагын дотор нүүр хуудсын загвар, жишээ хэвсрэлт

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ
Бүрэлдэхүүний / Салбар сургуулийн нэр



Зохиогчийн овог нэр


**НОМЫН НЭР
ДЭД НЭР**

Улаанбаатар хот

..... ОН

DDC 494.23.077 0-493

Зохиогч: Овог нэр, эрдмийн зэрэг, цол
Редактор: Овог нэр, эрдмийн зэрэг, цол
Техник редактор: Овог нэр, эрдмийн зэрэг, цол



Орчин цагийн монгол хэл, Сурах бичиг/ Зохиогчийн нэр, МУБИС, Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль, Улаанбаатар, 2016 он, хуудас 455

(Товч тодорхойлолт)

Энэхүү сурах бичгийг оюутан, магистрант, докторант, ЕБС-ийн багш нарт зориулав. Номын агуулга нь Монгол хэлний хөгжлийн түүх, бичиг үсгийн тойм, авиа зүй, үг зүй, өгүүлбэр зүй, нутгийн аялгуу судлал, үгийн сангийн судлал, эх судлал, найруулга зүй гэсэн хэсгээс бүрдэж буй бөгөөд чингэхдээ орчин цагийн монгол хэлний бүтэц тогтолцоот чанарын судалгаанд гарч байгаа, манай нэрт эрдэмтдийн гол бүтээлүүдийн үндсэн агуулгыг цогц, журамламал байдлаар тусгаж, нийтийн хэрэгцээний үүднээс хялбаршуулан, тогтсон нэр томьёо, үг хэллэгээр найруулав.

ЕБС-д судалж байгаа эх хэлний сургалтын агуулгын тогтвортой, цөм хэсгийг тогтоож, хэлний нэгжүүдийн бүтэц, утга, үүргийн талыг хэрэглээ, соёлтой холбон тайлбарласан журамламал хэл зүйн (нормативная грамматика) анхны цогц бүтээл болж байгаагаараа онол - хэрэглээний ач холбогдолтой юм.

МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Монгол хэлний тэнхимийн өргөтгөсөн хурал болон Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хэвлэхийг зөвшөөрөв.

ISBN:

Хэвлэсэн газрын мэдээлэл

© Зохиогчийн эрхийн мэдээлэл